

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН  
АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ  
ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч (цаашид “Арилжаа эрхлэгч” гэх)-ийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт, шалгалт хийж, холбогдох хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилт, учирч болзошгүй эрсдэлийн түвшинг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахад оршино.

1.2. Хяналт, шалгалт нь зайны болон газар дээрх хяналт, шалгалт гэсэн төрөлтэй байна.

1.3. Холбогдох төрийн байгууллагуудтай хамтран нэгдсэн хяналт, шалгалтыг хийхэд энэ журмыг баримталж болно.

ХОЁР. ЗАЙНЫ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

2.1. Зайны хяналт, шалгалтаар салбарын болон арилжаа эрхлэгчийн болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

2.2. Зайны хяналт, шалгалт хийх үйл ажиллагаа нь дараах үе шаттай байна:

2.2.1. арилжаа эрхлэгчээс ирүүлбэл зохих тайлан, мэдээг хянаж, үндсэн үйл ажиллагааны болон цаашид үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, санхүү, төлбөрийн чадварт үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.2.2. тайлан, мэдээг ирүүлээгүй, ирүүлсэн тайлан, мэдээ нь шаардлага хангаагүй бол тухайн арилжаа эрхлэгчээс шаардлага хангасан тайлан мэдээг нэн даруй ирүүлэхийг шаардах;

2.2.3. үндсэн үйл ажиллагаа, санхүү төлбөрийн чадварыг нь сайжруулах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгөх;

2.2.4. шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар, мэдээлэл, холбогдох баримт бичгийг шаардах;

2.2.5. шаардлагатай гэж үзвэл арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх саналыг Хорооны холбогдох удирдлагад танилцуулна.

2.3. Арилжаа эрхлэгчээс ирүүлсэн тайлан мэдээг хянаж, эрсдэлтэй гэж дүгнэсэн тохиолдолд тайлангийн хариуг цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ.

ГУРАВ. ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

3.1. Газар дээрх хяналт, шалгалтаар арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, журам зааварт нийцэж байгаа эсэхийг газар дээр нь баримтаар тогтоож, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээг авна.

3.2. Газар дээрх хяналт, шалгалтын төлөвлөгөө, газар дээрх хяналт, шалгалтын удирдамж (цаашид “Удирдамж” гэх), шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагчийг Хорооны дарга батална.

3.3 Удирдамжид шалгалтын зорилго, үндэслэл, шалгалтын төрөл, хүрээ, шалгалтад хамрагдах арилжаа эрхлэгчийн нэр, шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалт эхлэх болон дуусах хугацааг тусгана.

3.4. Газар дээрх хяналт, шалгалтыг үйл ажиллагааны хамрах цар хүрээгээр нь иж бүрэн, хэсэгчилсэн гэж ангилна.

3.4.1. иж бүрэн хяналт, шалгалтаар баталсан удирдамжийн хүрээнд холбогдох баримт бичигт тулгуурлан арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг бүхэлд нь хамруулж, үнэлэлт, дүгнэлт өгнө.

3.4.2. хэсэгчилсэн хяналт, шалгалтаар харилцагчдаас болон холбогдох бусад байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, эсхүл Хорооноос шалгах шаардлагатай гэж үзсэн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

3.5. Удирдамжийг шалгалтад хамрагдах арилжаа эрхлэгчид танилцуулснаар шалгалтыг эхлүүлнэ.

3.6. Иж бүрэн хяналт, шалгалтад хамрагдах арилжаа эрхлэгчээс дараах тайлан мэдээ, баримт бичгүүдийг шаардана:

3.6.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт, компанийн дүрэм;

3.6.2. тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг зохицуулсан дотоод дүрэм, журмууд;

3.6.3. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, холбогдох баримт бичиг, удирдлага зохион байгуулалтын талаарх мэдээлэл;

3.6.4. зайны болон газар дээрх хяналт, шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт, холбогдох баримт бичиг;

3.6.5. санхүүгийн болон холбогдох тайлан мэдээ;

3.6.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан томилсон шийдвэр;

3.6.7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан дотоод хяналтын хөтөлбөр, эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийн хэрэгжилт;

3.6.8. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээ, сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг хуульд заасан хугацаанд Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн талаарх баримт;

3.6.9. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд харилцагчийг таньж мэдэх үүргээ биелүүлсэн талаарх тайлан мэдээ, холбогдох баримт бичиг;

3.6.10. Хорооноос шаардлагатай гэж үзсэн холбогдох бусад баримт бичиг.

3.7. Арилжаа эрхлэгч нь хувь хүн бол дараах баримт бичгийг шаардана. Үүнд:

3.7.1. арилжаа эрхлэгчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт;

3.7.2. зайны болон газар дээрх хяналт, шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт, холбогдох баримт бичиг;

3.7.3. дансны хуулга;

3.7.4. санхүүгийн болон холбогдох тайлан мэдээ.

3.8. Хэсэгчилсэн хяналт, шалгалтад хамрагдах арилжаа эрхлэгчээс удирдамжид заасан баримт бичгийг шаардана.

3.9. Газар дээрх хяналт, шалгалтын тайлан (цаашид “Тайлан” гэх)-г шалгалтад хамрагдсан арилжаа эрхлэгчид удирдамжид заасан хугацаанд танилцуулна.

3.10. Тайлантай холбогдуулан хариу шаардсан бол арилжаа эрхлэгч тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд Хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

3.11. Тайланг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд тайлантай танилцсанаас хойш 10 хоногийн дотор Хорооны Улсын Ерөнхий байцаагчид бичгээр гомдол гаргаж болно.

3.12. Газар дээрх хяналт, шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгалтын ажлын хэсэг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

#### ДӨРӨВ. МЭДЭЭ, ТАЙЛАН

4.1. Арилжаа эрхлэгч нь эхний хагас жилийн тайланг 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 01 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар болон албан бичгээр ирүүлнэ. Үүнд дараах тайлангууд хамаарна:

4.1.1. Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, “Санхүүгийн тайлангийн А маягт”, “Санхүүгийн тайлангийн Б маягт”-ын дагуу санхүүгийн тайлан;

4.2. Арилжаа эрхлэгч нь дараах мэдээг улирал бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ:

4.2.1. үнэт металлын арилжааны мэдээ (Хавсралт 2);

4.2.2. үнэт чулууны арилжааны мэдээ (Хавсралт 3);

4.2.3. үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжааны мэдээ (Хавсралт 4).

4.3. Арилжаа эрхлэгч нь арилжаа хийх тухай бүрд хэрэглэгчийн систем эсхүл цахим төлбөрийн баримтын системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг арилжаанд оролцогч хувь хүн, хуулийн этгээдэд хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээнэ.

4.4. Арилжаа эрхлэгч нь хэрэглэгчийн системд бүртгэгдсэн арилжааны гүйлгээний мэдээллийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.3-т заасны дагуу гурав хоногийн дотор нэгдсэн системд илгээнэ.

#### ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1. Хороо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны ... дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 1 дүгээр хавсралт

**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ**

<b>№</b>	<b>ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>НИЙТ ТОО</b>
<b>1</b>	<b>Худалдан авсан үнэт металлын нийт үнийн дүн</b>	
1.2	Нийт харилцагчдын тоо (өссөн дүнгээр)	
1.3	Сорьц	
1.4	Нэгжийн дундаж үнэ	
1.5	Бохир жин	
1.6	АМНАТ-ийн суутгалын дундаж хэмжээ	
<b>2</b>	<b>Худалдсан үнэт металлын нийт үнийн дүн</b>	
2.1	Нийт харилцагчдын тоо (өссөн дүнгээр)	
2.2	Сорьц	
2.3	Нэгжийн дундаж үнэ	
2.4	Бохир жин	
2.5	АМНАТ-ийн суутгалын дундаж хэмжээ	
<b>3</b>	<b>Худалдан авсан үнэт чулууны нийт үнийн дүн</b>	
3.1	Нийт харилцагчдын тоо (өссөн дүнгээр)	
3.2	Нийт цэвэр жин	
<b>4</b>	<b>Худалдсан үнэт чулууны нийт үнийн дүн</b>	
4.1	Нийт харилцагчдын тоо (өссөн дүнгээр)	
4.2	Нийт цэвэр жин	
<b>5</b>	<b>Худалдан авсан үнэт эдлэлийн нийт үнийн дүн</b>	
5.1	Нийт тоо ширхэг (өссөн дүнгээр)	
5.2	Нийт жин (грамм)	
<b>6</b>	<b>Худалдсан үнэт эдлэлийн нийт дүн</b>	
6.1	Нийт тоо ширхэг (өссөн дүнгээр)	

	Нийт жин (грамм)	
7	Мэдээлбэл зохих гүйлгээ, харилцагчийн бүртгэлийн тоо	
7.1	Гүйлгээний нийт дүн (төгрөг)	

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны ... дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 2 дугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн нэр (хувь хүн бол хувь хүний нэрийг, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэрийг товчлолгүй бичнэ)				Хувь хүний овог, нэр:						Хүйс: <input type="checkbox"/> Эр <input type="checkbox"/> Эм	
				Хуулийн этгээд:							
№	Огноо	Баримтын дугаар	Үнэт металлын нэр, төрлийг сонгоно уу. (алт, мөнгө, платина, палладий, иридий, родий, рутений, осми)	Худалдсан/ худалдан авсан (сонгох)	Сорьц	Нэгжийн үнэ	Бохир жин (грамм)	АМНАТ-ын суутгал (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Тухайн үнэт чулууг олборлосон аймаг, сум, баг, газар	Үнэт металл тушаасан банкны нэр
1											
2											
3											
<b>Нийт</b>											

ТАЙЛАН ГАРГАСАН: .....(.....)

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны ... дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 3 дугаар хавсралт

ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн нэр (хувь хүн бол хувь хүний нэрийг, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэрийг товчлолгүй бичнэ)				Хувь хүний овог, нэр:						Хүйс: <input type="checkbox"/> Эр <input type="checkbox"/> Эм	
				Хуулийн этгээд:							
№	Огноо	Баримтын дугаар	Үнэт чулууны нэр, төрлийг сонгоно уу. (Доржпалам, Бадмаараг, Маргад эрдэнэ, Индранил, Сувд)	Худалдсан/ худалдан авсан (сонгох)	Цэвэр жин (грамм)	МБ-ны ам.дол/төгрөгийн ханш	ОУЗЗҮнэ ам.доллар	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	Тухайн үнэт чулууг олборлосон аймаг, сум, баг, газар	
1											
2											
3											
<b>Нийт</b>											

ТАЙЛАН ГАРГАСАН: .....(.....)

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны ... дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 4 дүгээр хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУГААР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн нэр (хувь хүн бол хувь хүний нэрийг, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэрийг товчлолгүй бичнэ)			Хувь хүний овог, нэр:					Хүйс: <input type="checkbox"/> Эр <input type="checkbox"/> Эм	
			Хуулийн этгээд:						
Д/д	Үнэт металлын нэр	Худалдан авсан			Худалдсан			Үнэт чулууны нэр <sup>1</sup>	
		Үнэт эдлэлийн тоо (ширхэг)	Жин (грамм)	Үнийн дүн (төгрөг)	Үнэт эдлэлийн тоо (ширхэг)	Жин (грамм)	Үнийн дүн (төгрөг)		
1	Алт								
2	Мөнгө								
3	Платина								
4	Палладий								
5	Иридий								
6	Родий								
7	Рутений								
8	Осми								
<b>НИЙТ</b>									

ТАЙЛАН ГАРГАСАН: .....(.....)

<sup>1</sup> Үнэт металлаар хийсэн эдлэлд Эрдэнэсийн сангийн тухай хуульд заасан үнэт чулуу (доржпалам, бадмаараг, маргад эрдэнэ, индранил, сувд) орсон тохиолдолд нэрсийг бичнэ үү.